БЗӨБЦТС ТӨХК

# БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 09 сарын 23 өдөр Дугаар А/281 Улаанбаатар хот

Шилэн дансны цахим хуудаст мэдээлэл оруулах хяналт тавих ажилтныг томилох тухай

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь хэсэг, Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Шилэн дансны цахим хуудсанд компанийн үйл ажиллагааны зохих мэдээллийг өгөгдсөн маягт, журмын дагуу хөтөлж, ил тод болгох чиг үүрэг бүхий админ болон мөнгөн хөрөнгийн нягтлан бодогч нар солигдсон тул дараах бүрэлдэхүүнтэй өөрчлөн томилсугай.

Админ: Д.Насанжаргал (Санхүүгийн хяналтын мэргэжилтэн)

Хэрэглэгч:

Г.Энхтүвшин (Төлөвлөлт эдийн засгийн хэлтсийн дарга)

Т.Болдсанаа (Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга, Ерөнхий нягтлан бодогч)

Б.Тайванзаяа (Эдийн засагч)

Ц.Оюундэлгэр (Мөнгөн хөрөнгө хариуцсан нягтлан бодогч)

А.Батцэцэг (Хангамжийн мэргэжилтэн)

М.Нарантуяа (Хүний нөөцийн мэргэжилтэн)

2. Шилэн дансны цахим хуудсанд тус компаниас байршуулах мэдээллийн нэр, хугацаа, хариуцах ажилтны жагсаалтыг хавсралтад заасны дагуу батлахсугай.

3.Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг хуулийн хугацаанд хэрэгжүүлсэн эсэхэд хяналт тавих, шилэн дансны хэрэглэгч болон тэдгээрийн удирдлагад зөвлөмж чиглэл өгч удирдлагаар хангаж ажиллахыг Хяналт аюулгүй ажиллагааны хэлтсийн дарга (Э.Намуунбаяр)-т даалгасугай.

4.Шилэн дансны цахим хуудсанд оруулах мэдээллийн үнэн зөв эсэхийг шалгаж, хуулийн хугацаанд ил тод болгох ажлыг удирдан зохион байгуулахыг Төлөвлөлт эдийн засгийн хэлтсийн дарга (Г.Энхтүвшин), Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга, Ерөнхий нягтлан бодогч

1212518

(Т.Болдсанаа), Худалдан авах ажиллагаа хангамжийн хэлтсийн дарга (Б.Гүррагчаа), Захиргаа хүний нөөцийн хэлтсийн дарга (Я.Отгонзул) нарт тус тус үүрэг болгосугай.

5.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн А/128 тоот тушаалыг хүчингүйд тооцсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Х.ГАНЧУЛУУН